



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Халхгол сумын Нөмрөгийн Дархан Цаазат газрын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/79/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он	Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn Аудитор: У.Энхчимэг Утас: 7000-3775 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
Менежментийн захидал	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	10





2.1. Оршил

“Халхгол Нөмрөгийн дархан цаазат газрын захиргаа”-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Г.Батболд Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Нөмрөгийн дархан цаазат газрын захиргаа”-ны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Халхгол Нөмрөгийн дархан цаазат газрын захиргаа”-ны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 24-нээс 2020 оны 02 дугаар сарын 06-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорнод аймгийн Төрийн аудитын газрын захиалгаар “Хаан консалтинг аудит” ХХК-ийн аудитор У.Энхчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

“Халхгол Нөмрөгийн дархан цаазат газрын захиргаа”-ны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймгийн Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Халхгол Нөмрөгийн дархан цаазат газрын захиргаа”-ны үйл ажиллагааны эрхэм зорилго нь Тусгай хамгаалалттай газар нутгийн эко системийг унаган төрхөөр нь хамгаалж хойч үедээ өвлүүлэхэд оршино.

“Халхгол Нөмрөгийн дархан цаазат газрын захиргаа”-ны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх
- Ан амьтны амьдрах орчныг сайжруулах, биотехникийн арга хэмжээ авах
- Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус “Халхгол Нөмрөгийн дархан цаазат газрын захиргаа”-ны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Халхгол Нөмрөгийн дархан цаазат газрын захиргаа” нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

“Халхгол Нөмрөгийн дархан цаазат газрын захиргаа”-ны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Халхгол Нөмрөгийн дархан цаазат газрын захиргаа” -ны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 10 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайлангийн зардлын үзүүлэлтийг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 152,728.5 мянган төгрөгөөс тооцон 3,054.57 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.



Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 3,054.57 мянган төгрөгөөр тооцсон нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн чухал үзүүлэлт болох зардлаас материаллаг байдлын түвшинг тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Халхгол Нөмрөгийн дархан цаазат газрын захиргаа” –ны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,750 .00 мянган төгрөгөөр буюу 6.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00.00	00.00	00.00
Авлага	32.9	00.00	-32.9
Урьдчилгаа	00.00	00.00	00.00
Бараа материал	10,767.3	19,600.2	8,832.91
Үндсэн хөрөнгө	206,230.9	209,206.5	2,975.6
Хуримтлагдсан элэгдэл	(44,349.7)	(45,375.3)	(1,025.6)
Нийт хөрөнгө	172,681.49	183,431.49	10,750.01
Өр төлбөр	00.00	00.00	00.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	172,681.49	183,431.49	10,750.01
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	172,681.49	183,431.49	10,750.01

Авлага дансны үлдэгдэл буурсан нь бэлтгэн нийлүүлэгчээс авах бараа материалын үлдэгдлийг авснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 8,832.91 төгрөгөөр өссөн нь байгаль хамгаалагч нарын ажил үүргээ гүйцэтгэхэд зориулж уналгын морь худалдан авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь хөрөнгө оруулалт хийгдсэнээс шалтгаалжээ.

Төсвөөр 19,379.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан дүнгээр нэмэгдэж, ТӨБЗГ-ын тогтоолоор акталсан 16,403.5 мянган төгрөгийн хөрөнгийн дүнгээр буурсан байна.

Биет бус хөрөнгийн дүнд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл үлдэгдэл тайлант хугацааны эцэст 0.00 төгрөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 183,431.49 мянган төгрөг болж 10,750.01 мянган төгрөгөөр өссөн нь дээрх бараа материалын болон үндсэн хөрөнгийн өсөлтөөс шалтгаалжээ.



2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар “Халхгол Нөмрөгийн дархан цаазат газрын захиргаа” нь тайлант онд 2,200 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 92.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 4.2 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого /тасалбар/	2,200.0	92.1	2,107.9	4.2
Нийт дүн				

Үндсэн үйл ажиллагааны орлого болох Дархан цаазат газарт нэвтэрсэн дотоодын болон гадаадын жуулчдаас олох тасалбарын орлого тасарсанд тасалбарын үнэ хэт бага, жуулчид цөөн тоогоор аялдаг, аялал жуулчлал муу хөгжсөн нь нөлөөлсөн байна.

Халхгол Нөмрөгийн дархан цаазат газарт дотоодын жуулчин 300 төгрөг, гадаадын жуулчин 3000 төгрөгийн тасалбараар нэвтэрч байгаа нь хэт бага үнэ байна. Тайлант онд 300 гаруй жуулчин хүлээн авсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 134,702.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 134,702.4 урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 132502,4 мянган төгрөгийг улсын төсвөөс 2,200.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил нь 98,994.2 мянган төгрөг батлагдсанаас 94,452.8 мянган төгрөг зарцуулж 4.5 сая төгрөг хэмнэсэн буюу 95.4 хувьтай байна. Хэмнэлт үүссэн шалтгаан нь 2019 онд зарим албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон зэрэг дэвийн нэмэгдлийг нэмэхээр тооцсон ч гүйцэтгэлээр нэмэгдээгүйтэй холбоотой байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 4380.9 мянган төгрөг төлөвлөснөөс 3691.1 мянган төгрөг зарцуулж 689.7 мянган төгрөг хэмнэсэн буюу 84.3 хувьтай байна.

Энэ нь түлш халаалтын зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 128,832.3 мянган төгрөг буюу 95.6 хувьтай байна. Зарцуулаагүй үлдэгдлийн 3,762.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцааж төвлөрүүлжээ.

Нэмэлт төсөв: Байгаль, орчин уур амьсгалын сан цөлжилтийг сааруулах төслөөс байгаль хамгаалагчдын эргүүл хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор уналгын морь авах зардлыг санхүүжүүлэхэд зориулж 9,900.0 мянган төгрөг, БОАЖЯ-наас төрийн хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал хөгжүүлэх зорилгоор 3,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.



2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 10 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 13 эрсдэл тодорхойлж нийт 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 5,107.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 3000.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,107.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө гүйцэтгэл, үндсэн хөрөнгийн бүртгэлийг анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

“Халхгол Нөмрөгийн дархан цаазат газрын захиргаа” Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 139 мэдээлэл байршуулахаас 134 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 5 мэдээллийг интернэтийн саатлаас шалтгаалан хугацаа хоцроож мэдээлсэн байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,000.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснээс тус албан шаардлага хэрэгжээгүй байна.

Нийт 1 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид *Халхгол Нөмрөгийн дархан цаазат газрын захиргаа* -ны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

“Халхгол Нөмрөгийн дархан цаазат газрын захиргаа”-ны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын **агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс** урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг биелүүлэхтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө биелээгүй.

1.2. Эрсдэл:

Орлогын төлөвлөгөө тасрах, холбогдох зардал санхүүжилтгүй болох.

1.3 Өгсөн зөвлөмж:

Өөрийн орлогын төлөвлөгөөг зөв төлөвлөх, тасалбарын үнэ нэмэгдүүлэх саналыг БОАЖЯ-нд хүргүүлэх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:
Зөвлөмжийг биелүүлнэ.

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Ээлжийн амралтын мэдээгдэл буруу гаргасан.

2.2. Эрсдэл:

Ажлаас гарч байгаа ажилчдын цалингийн эцсийн тооцоо буруу хийгдэх

2.3. Өгсөн зөвлөмж:



Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар батлагдсан “Ээлжийн амралт олгох заавар”-ыг мөрдөж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/